

болжээ. Үг зууны дундуур Жужаны Анахуан хааны үед тэдний бослого хөдөлгөөн маш ширүүссэн учир Анахуан түүнтэй тэмцэж байгаад ялагдаж, амиа хорложээ. 552 онд Жужаны хаант улс Ашина овгийнхон тэргүүтэй түрэгүүдэд цохигдон - мөхөөд үлдсэн хүн ам нь түрэгийн ноёрхолд орж, 130-аад мянган хүн алс баруун зүг халин гарчээ. Хальж гарагсад нь Дундад Азиар дамжин Дорнод Европт хүрч 558 оноос хойш обор буюу авар¹¹ гэж алдаршаад Унгарт ихэнхдээ үлдсэн байна. Туркүүд Жужан нарыг обор буюу авар гэж нэрлэдэг байсан нь санамсаргүй хэрэг биш байжээ. Обор, авар гэсэн хоёр үгний аль аль нь монгол хэлэнд өөр утгаар одоо болтол байж байгаа. Обор /овор гэж том жижгийн хэмжээ, үндсэндээ нэлээд том гэсэн утгатай үг. Авар гэвэл ямарваа аюул заналаас авар гэсэн утга илтгэнэ. Энэ бүхэн хэдий сонин боловч одоогийн монголын обор, авар гэдэг өөр өөр утгатай үгийг Жужантай шууд холбон үзэж болохгүй байх аа. Харин жужан нарыг хожмын монголын татар нарын өвөг дээдэс мөн байв гэж үзэх нь үнэн байдалд илүү нийцнэ.

Зүүлт

1. Denis Sinor, Inner Asia (History-Civilization-Languages), Bloomington, 1971, pp. 97-100.
2. Мөн тэнд, 101-112.
3. Жужаны баримтын эмхэтгэл, Бээжин, 1962, 4-р тал хятадаар/
4. Мөн тэнд, 8-9-р тал.
5. Мөн тэнд, 4-р тал.
6. БНМАУ-ын түүх, гурван боть зохиол, тэргүүн боть, Улаанбаатар, 1966, 117-р тал /монголоор/
7. Г.Сүхбаатар, Монголчуудын эртний өвөг, Улаанбаатар, 1980, 115-р тал.
8. А.Лувсандэндэв. Хэл бичгийн ухааны зарим асуудал, Улаанбаатар, 1980, 12-р тал.
9. 1. Denis Sinor, Inner Asia (History-Civilization-Languages), Bloomington, 1971, pp.28.
10. Жужаны баримтын эмхэтгэл, Бээжин, 1962, 42-р тал / хятадаар,
11. Denis Sinor, Inner Asia, Pp. 145-150.

ГАДААД МОНГОЛЫН АВТОНОМИЙГ УСТГАСАН НЬ (1919 он)

Е.А.Белов

Бээжингийн «Чень бао» сонины 1919 оны 6 сарын 12-ны дугаарт «Гадаад Монголын байдлын аюул» нэртэй өгүүлэл нийтлэгдэв. Уг өгүүлэлд Хүрэн дэх амбан сайд Чень-И-гээс БНХУ ын ерөнхийлөгчид явуулсан цахилгаан утаснаас иш татаж атаман Семенов Гадаад Монгол руу аян хийж хятадын цэргийг хөөн гаргах

асуудлыг хэлэлцэж байгаа ба оросын хил дээр буй Монголын цэрэг оросын буриадуудтай нягт холбоо тогтоогоод байна гэжээ. Амбан сайд эцэст нь Гадаад Монгол хүнд аюултай байдалд ороод байгаа тул Бээжингийн засгийн газар монголд цэргээ илгээх ёстой гэжээ.²

Хаалганаас автомашинаар гарсан хятадын цэргийн эхний хэсэг 1919 оны 7 сарын эхээр Хүрээнд орж ирэв.³ Кудашёваас Хятадын гадаад яаманд хандаж ямар учраас ингэж байгаа тухай лавлан асуухад сайд Чэнь Лу шинээр цэрэг илгээсэн явдал бол «гагцхүү Семеновын цэрэг Гадаад Монголд цөмрөн орох аюулаас үүдсэн бөгөөд Хятадын үүрэг бол Монголд дэг журмыг хамгаалахад нь туслах ёстой хэмээн мэдэгджээ. БНХУ-ын ерөнхийлөгч Сюй Шичан 7 сарын 16-нд зарлигаараа «Баруун хойд хязгаарыг /Сибэй гоубяньши илбэн тохинуулагч» амбан тушаалыг бий болгож энэ албанд Дуань Цижуйн толгойлсон Аньхойн цэргийн бүлгийн дэслэгч генерал Сюй Шужэнийг томилон. Сюй. Шужэний үйл ажиллагааны хүрээнд Гадаад Монгол ч орж байлаа. Илбэн тохинуулагчид Хүрээн дэх амбан сайд Чэнь И болон түүний Маймаачин, Улиастай, Ховд дахь туслахууд захирагдах болов.⁵ 7 сарын 20-нд Сюй Шичаны зарлигаар Дуань Цижуйгаар удирдуулсан «Хилийн хамгаалалтын хэрэг эрхлэх товчоо» байгуулав.

Дуань Цижуй нэгдүгээрт Омскийн засгийн газрын сул байдал, хоёрдугаарт атаман

Семеновын Гадаад Монголд учруулж буй заналхийлэл, гуравдугаарт Хятадад заналхийлж буй улааны халдварын аюул зэргийг тоочиж баруун хойд хилийг хамгаалахад зориулж нэлээд хэдэн дивиз шинээр байгуулах саналаа ерөнхийлөгчдөө захидлаар танилцуулжээ.⁶

Баруун хойд хилийг илбэн тохинуулагчийг томилон, түүнд Хүрээн дэх амбанг захируулсан, монголд цэрэг оруулж эхэлсэн зэрэг явдлууд нь Гадаад Монголын автономийг устгаж Хятадын засаг захиргааг бүрэн утгаар нь сэргээн босгох гэсэн Бээжингийнхний санааг гэрчилж байлаа.

1919 оны 10 сар болтол Монголын удирдлагад хандаж тус засгийн газар өөрийн автономийг устгахын төлөө байна уу? үгүй бол энэ нь цуурхал эсэх талаар тодруулах гэсэн Орловын хүсэлтийн хариуд Цэрэндорж автономийг халах тухай цуурхал нь «өдөөн хатгалга»-ын шинжтэй бөгөөд монголын засгийн газар Хятадын төлөөлөгчидтэй энэ мэт асуудлыг хэлэлцээгүй гэсэн хариултыг тогтмол өгч байв⁷. Гэвч үнэн хэрэг дээрээ Хүрээний засгийн газар 1919 оны зун оросын дипломатаас далдуур Чэнь И-тэй Гадаад Монголын автономийг устгах нөхцлийн асуудлаар хэлэлцээ хийж байжээ. Хэлэлцээрийн явцад «Хятадын засгийн газраас автономийг өөрөө халсны дараа Гадаад Монголыг хүндэтгэн үзэх ба түүний байдлыг ирээдүйд сайжруулах тухай» гэсэн 64 зүйл бүхий баримт

бичиг гаргажээ. Баримт бичигт Гадаад монгол нь Хятадын бүгд найрамдах улсын таван үндэстний бүрэлдэхүүнд нэгдэж орох⁸ ба ингэснээрээ Хятадын засгийн газрын талархлыг хүлээнэ. Харин монголын засаг захиргааг Хятадын Хүрээн дэх амбан сайд болон түүний Улиастай, Ховд, Маймаачин дахь туслахууд гартаа авна. Мөн 60 дугаар зүйлд Гадаад Монголын автономии өөрөө устгаснаар Хиагтын гурван этгээдийн гэрээ аяндаа хүчингүй болохыг урьдчилан зааж өгчээ.

Гэрээ бичгийн ёсоор Жавзандамба хутагтын хаан цолыг хэвээр үлдээж, харин төр барих эрхийг хасч, хаан болон эх дагинд Бээжингийн засгийн газар жил бүр их хэмжээний цалин пүнлүү олгох болжээ.

Хүрээнд 9 сард Автономит Монголын дотоод гадаад бодлогын асуудал болон нармай монголын хөдөлгөөнд хэрхэн хандах тухай асуудлыг авч хэлэлцсэн хошууны ноёдын их хурал болов. Автономийг устгах талыг баримтлагч зарим сайд нэр хүнд бүхий хүмүүс энэ их хурлыг гадаад монголын Хятадын харъяанд бүрэн шилжиж орох үзэл санаагаа ноёдын дунд суртачлахад ашиглав. Тэрхүү үзэл санааг идэвхтэй сурталчлагчид нь гадаад яамны сайд Цэрэндорж, Шүүх яамны сайд Цэцэн хан Навааннэрэн, Богд хааны зөвлөх Чин улсын үед Хүрээнд амбан сайд байсан ван Ширнэндамдин нар байлаа. Нууц эх сурвалжаас Орловын олж авсан мэдээгээр 1919 оны 10 сар гэхэд монголын ноёдын дийлэнх нь Гадаад Монголын автономийг устгаж хятадад бүрэн нэгдэхийн төлөө байжээ¹⁰.

Автономийг халах талыг баримлагчдын толгойлогч нь монголын сүм хийдийн томоохон феодалуудын нэг засгийн газрын тэргүүн Бадамдорж байв. Бадамдоржийн Хятадын талыг баримтлагчдын талд шилжиж орсон явдлыг А.Орлов энэхүү өндөр албаны лам ёс суртахуунаар ялзарч гүйцсэн хүн бөгөөд улсын санг хулгай хийж хээл хахууль авдаг асуудалтай холбон тайлбарлажээ. Тэрбээр Гадаад Монголын автономийг устгахад тусалснаараа өөрийн байр суурь эд хөрөнгөө Бээжингийн эрх баригчдын зүгээс хамгаалан ивээнэ гэж тооцож байсан нь илэрхий.

Чэнь И 1919 оны 9 дүгээр сарын 30-нд Гадаад Монголын автономийг устгах нөхцлийн тухай Цэрэнддоржтой хамтран боловсруулсан баримт бичгийг Бээжин рүү илгээв. 10 сарын сүүлч гэхэд Хүрээнд дөрвөн мянга илүү хүнтэй Хятадын холимог бригад ирчихээд байлаа.¹¹ Богд хаан улсынхаа автономийг хэвээр үлдээх горьдлого өвөрлөж 10 сарын 26-нд нэр нөлөө ихтэй лам Жалханз Хутагтаар БНХУ-ын ерөнхийлөгчид захидал илгээв. Богд хаан захидалдаа «гадаад монголд хятад цэрэг шалтгаангүй орж ирсэн ба

Хүрээн дэх Хятадын төлөөлөгч Чэнь и/-өөс түүний эсрэг хийж буй далд явууллага зэрэгт ерөнхийлөгчийн анхаарлыг хандуулаад улмаар энэ мэт явдлыг төгсгөл болгох»-ыг хүсчээ. Жалханзад өгсөн өөр нэг үүрэг нь: Ерөнхийлөгчид хандаад амжилт олохгүй бол ирээдүйд Хятадын захиргааны үед Богдын эзлэх байр суурийг хятадуудтай наймаалцаж аль болох сайн нөхцлийг түүнд болон шавь нартаа олгож авах явдал байв¹².

10 сарын 29-нд Хүрээнд генерал Сюй Шужэн хүрэлцэн ирэв. Тэрбээр монголын сайд нарт бараалхаж бэлэг гардуулан Хужир буланд цэргийн ёслолын жагсаал үйлдэж түүнд нь монголын сайд ноёдууд оролцов. Дараа нь монголын сайд ноёдод зориулж зоог барьж театрчилсан үзвэр сонирхуулав. Тэгэвч Богд хаан Сюй Шужэнийг хүлээж авахаас татгалзсан хэвээр засгийн газар болон ноёдууд Гадаад Монголын автономийг халахыг эсэргүүцэж саналаа хэлэхийг найдан хүлээсээр л байлаа.

Омскийн засгийн газар болон Бээжин дэх Оросын төлөөлөгчийн газар гадаад монголын автономийг устгахын эсрэг байв. И.И.Сукин 11 сарын 2-нд Кудашёв хятадууд асар удахгүй монголын автономийг устгах санаатай байгааг мэдэгдээд элчин төлөөлөгчийг хятадын засгийн газарт очиж Хүрээнд Хятадын цэрэг бөөгнөрөх ямар ч шаардлага байхгүй бөгөөд» нармай монголын цэргийн давшилтын болон Семеновынхны аюул үгүй болсон» явдлыг хэлж ойлгуулахыг хүсчээ. Колчакийн засгийн газрын гадаад хэрэг эрхлэгчээс цааш нь : Орос улс монголд хамаарах гэрээний үүргийг Хятадын тал зөрчихтэй хэзээ ч эвлэрч чадахгүй» гэжээ.¹³

Гэвч Омскийн засгийн газар хэдийн бат бэх биш болж Колчакийн цэрэг Улаан армийн өмнө удаа дараа ялагдал хүлээх болов. Мэдээжийн энэ шалтгаанаар Кудашёв хятадын засгийн газартай харьцахдаа болгоомжлох болжээ. Тэрбээр 11 сарын 3-нд Вайцзяобуд захидал илгээж Хүрээнд дөрвөн мянган хүнтэй цэрэг бөөгнөрч байгаа явдлыг ямар ч талаар зөвтгөх аргагүй гээд « Энэ нь Хиагтад 1915 онд тогтоосон гэрээний хэм хэмжээнд таарахгүй» юм гэж зааснаар хязгаарлажээ. Хятадын гадаад яам Оросын төлөөлөгчийн захидалд хариулсангүй.

Гадад Монголын автономийг устгах үйл явц хүчээ авав. Чэнь и Цэрэндорж нарын боловсруулсан 64 зүйлийн нэлээд нь тэр ч бүү Хэл автономийг халах хэлбэр нь ч Сюй Шужэнд таалагдахгүй байлаа. Үүний учир нь энэхүү баримт бичиг монголын дээдэс болон хятадын засгийн газрын хооронд ямар нэгэн гэрээ байгуулахад хүргэх нь илт байлаа. Сюй Шужэн хүчин эрдэж Монголчуудыг эрс дарамтлан автономии өөрсдийн сайн дураараа устгаснаа зарлаж Хятадын бүрэн эрхт захиргаанд орохоо илэрхийлж Бээжингийн засгийн газраас гуйсан өргөх бичиг үйлдүүлэхээр шийдэв. Сюй Шужэн Чэнь и нар

хамгийн богино хугацаанд дээрх утгатай өргөх бичгийг монголын засгийн газраас гаргаж өгөхийг шаардав. Ийм нөхцөлд Богд хаан автономийг халах асуудлыг Дээд Доод хуралд хэлэлцүүлэхээр оруулав.

Эдгээр Дээд Доод Хурлууд бол төлөөлөгчдийн байгууллага биш харин Дээд түшмэдүүдийн байгууллага байлаа. Дээд хурал дотоод гадаад, сан, шүүх, цэргийн яамдын сайд нар мөн тэдгээрийн дэд сайдуудаас бүрдэж байв. Доод хуралд эдгээр таван яамны бүх түшмэдүүд орж байжээ.

Доод хурал Дээд хурлын эсрэг байр суурь баримталж Гадаад Монголын автономийг хадгалахын төлөө байлаа. Энэ нь ч тохиолдолын хэрэг бус Монголын түшмэдийн давхарга үнэн чанартаа монгол улс тусгаар тогтнолоо зарласан 1911 оны 12 сараас хэлбэршин тогтнож эхэлсэн юм. Үүнээс өмнөх үед Монголд түшмэдүүд нь үндсэндээ манж, хятадууд байлаа. Чухамдаа 1911-1915 онд тусгаар тогтносон Монгол улсыг өөрийнх нь түшмэдүүд удирдаж байлаа. Автономит Монгол 1915-1919 онуудад мөн монгол түшмэдийн гарт байлаа. Энэ тусгаар тогтносон болон Автономит Монголын найман жилийн дотор улсын цалингаар дийлэнх хэсэг нь амьдардаг бүхэл бүтэн түшмэдийн давхарга үүсэн бүрэлджээ. Хэрэв Гадаад Монголын автономийг устгахад хүрвэл монгол түшмэдүүдийг хан үндэсний түшмэдээр сольж монгол түшмэдүүд ажилгүй болж цалин пүнлүүгүй үлдэх байлаа.

Лам нар болон хошуудаас хүрээнд ирээд байсан ноёдын оролцоотойгоор дээд доод хурлын хамтарсан хуралдаан 11 сарын 8-нд Бадамдоржийн удирдлага дор болов.

Хурлын илтгэлийг Цэрэндорж тавьж Орловын тэмдэглэснээр Гадаад монгол нь «өөртөө засах эрхтэй улс»ын хувьд цаашид оршин тогтнох боломжгүй болсон байдлыг засгийн газар ухамсарлахад хүргэсэн олон улсын нөхцөл байдлыг дүрслэн үзүүлж Чэнь Игийн харилцан тохиролцож чадсан автономийг халах нөхцлийн тухай зүйлүүд болон хараахан тохиролцоонд хүрээгүй байгаа зүйлүүдийг ч тоочсон байна.¹⁵

Илтгэлийн дараа хамгийн түрүүнд Хүрээний цагдаагийн дарга Цэмбэл бэйс үг хэлэв. Автономийг халах асуудлыг «засгийн газар урьдаас шийдчихсэн болохоор энд байгаа хүмүүст үнэн хэргийн хийх юм байхгүй»¹⁶ гэж мэдэгдээд саяхан болтол - барга, өвөрмонгол буриадууд халхтай нэгдсэн нэгдмэл монгол улс болох гэсэн хүсэлтийг засгийн газраас Хиагтын гэрээнд харш хэмээн хэрэгсэхгүй болгож байснаа¹⁷ яахлаараа одоо энэ гэрээгээ зөрчиж монголчуулыг Хятадын албат болгох боломжтой гэж үзэж байгаагийн учрыг ойлгохгүй байна гэжээ. Цагдаагийн албаны даргыг дэмжиж Богд хааны шадар хүрээний хүн болох Түшээ гүн Баатарбадрах ямар учраас засгийн газар Оросын зөвшөөрөлгүйгээр Хиагтын гэрээг

зөрчсөн, Хятадын төлөөлөгчидтэй хийж байгаа хэлэлцээгээ засгийн газар яагаад Оросын дипломат төлөөлөгчид мэдэгдээгүйд гайхаж байна гэжээ. Үүний хариуд Цэрэндорж «Хиагтын гэрээ баталсан Орос улс одоо оршин байгаа больсон шүү дээ¹⁸ хэмээн тэмдэглэжээ.

Үүгээр дээд доод хурлын хамтарсан хуралдаан дуусаж хуралд оролцогчдыг Халхын дөрвөн аймаг тус бүрээр тус тусдаа цуглаж хэлэлцэж буй асуудлаар зохих шийдвэр гаргах санал дэвшүүлэв. Тэр оройдоо тус тусдаа хурлууд болж автономийг халахын эсрэг түшмэдүүд ба лам нар олонхи болж байсан хурлуудаас автономийг хадгалах тухай хурлын шийдвэрээ бичгээр гаргаж засгийн газраар дамжуулан Богд хаанд илгээв.¹⁹

Хурлын шийдвэр бүхий захидлыг Богд хаан аваад Сюй Шужэн Чэнь И хоёрыг хүлээн авч Гадаад Монголын автономийг халах ямар ч шалтгааныг олж харахгүй байна хэмээн мэдэгджээ. Гэвч генералууд ойрын өдрүүдэд автономийг зүйл дуусгах шийдвэр төгс байсан учраас мэдэгдлийг чихнийхээ хажуугаар өнгөрөөв. Сюй Шужэн Хүрээний хутагтад хандаж монголын ламын шашны тэргүүн болон түүний шавь нарын ирээдүйд төвхнөх тухай асуудлын чирэгдлийг өөртөө хүлээж авлаа гээд Гадаад Монгол Бээжингийн бүрэн захиргаан дор орох үед ч энэ талын асуудлыг хохироохгүй хэмээжээ. Богд хаан генералуудтай хэлэлцээ хийлгэхээр Бадамдоржийг томилсноо мэдэгдэв.

Хэлэлцээр хүнд хэцүү болж Бадамдоржид автономийг хадгалахын төлөө талынхан, засгийн газрын зүгээс болон хутагтын ойр тойрны зүгээс дарамт шахалт үзүүлж байлаа. 11 сарын 14-нөөс 15-нд шилжих шөнө Сюй Шужэний тушаалаар Чэнь и Бадамдорж дээр ирж хэрвээ дараа өдрийн оройн найман цаг гэхэд түүнд Гадаад Монголыг Хятадын захиргаанд бүрэн оруулж авахыг хүссэн Хүрээний засгийн газрын өргөх бичгийг гардуулахгүй бол хутагт болон Бадамдорж хоёрыг машинд суулгаж Бээжинд аваачих болно²¹ гэсэн тулган шаардах бичиг гардуулав. 11 сарын 15-ны өглөө засгийн газрын тэргүүн Богд хаан дээр орж тулган шаардах бичгийн тухай илтгэв. Монголчуудын «амьд бурхан» . Хятадуудын шаардлагыг эсэргүүцэх Зэвсэгт хүчин алга. Иймд дээд доод хурлыг дахин цуглуулж асуудлыг шийдэхийг Бадамдоржоос хүсчээ.²²

Зэвсэгт хүчний тухайд бол хутагт ба түүний засгийн газарт хүрэлцэх хэмжээний цэрэг байсангүй. Үүнд тэд өөрсдөө л буруутай байлаа. Нэгдүгээрт, монголын удирдагчид зэвсэгт хүчнийг үүсгэн байгуулахад хангалттай анхаарал тавиагүй. 1919 он гэхэд тэдний

мэдэлд 2 мянган цэрэг байснаас ихэнхи нь муу сургаж бэлтгэсэн сахилга батгүй байлаа. Хоёрдугаарт, энэ 2 мянган цэргийн гол цөм болж байсан оросын цэргийн сургагчдын сургасан анги салбарууд 1919 оны зунаас Урианхайн хязгаарт байрлаж байв. Учир нь Хүрээний засгийн газар болон Бээжингийнхэн 1918-1919 онд Урианхайн хязгаарыг Оросын ивээн эзэрхэх / протекрат/ эрхээс салгаж өөрсдийн эрхшээлд оруулах харилцан уялдуулсан үйл ажиллагаа явуулж²³ 1919 онд Урианхайн хязгаарт цэргийн ангиудаа оруулсан юм. Гурван зуун цэрэгтэй монголын ангийг 1920 оны зун Урианхайгаас татаж авсан ба харин үлдсэн Хятадын цэргийн ангиуд 1921 онд Улаан армийн ангиудад цохигдсон билээ.

Гадаад Монгол цэргийн талаар сул дорой байсан явдал түүний Хятадын захиргаанд бүрэн ороход нөлөөлсөн гол шалтгааны нэг болжээ.

1 сарын 15-нд үд дунд дээд доод хурлынхан Гадаад яамны байранд цуглав. Энэ үед хотын төвөөс. Богд хааны зам гэж нэрлэгддэг замын дагуу Туул голын эрэг дэх Хутагтын ордон хүртэл Хятад цэрэг жагссан байв. Мөн Цэрэндоржийн байшинг Сүй Шужэний цэрэг бүсэлжээ. Доод хурлын гишүүд Хүрээг Хятадын удирдлагад орохыг эсэргүүцэж байсан хэдий ч Гадаад Монголын автономийг устгах тухай өргөх бичигт тэр оройдоо таван яамны сайд тэдний арван нэгэн дэд сайд нар гарын үсэг зуржээ. Гарын үсэг зурсан бичгийг Богд хааны тамга даруулахаар илгээсэн боловч тэрбээр тамгаа дарахаас татгалзав. Үүний дараа өргөх бичгийг 11 сарын 17-нд Сүй Шужэнд гардуулан өглөө.²⁴ «Гадаад Монголын засгийн газар ноёд ба лам нарын хамтарсан өргөх бичиг»-т өгүүлэхдээ Чингийн захиргааны сүүлийн жилүүдэд манж хятадын засаг захиргааны зүгээс гадаад монголчуудад зүй бус аашилсан явдал гарсан. Үүнийг гадаадынхан (оросууд ашиглаж монголчуудыг тусгаар тогтнох замд өдөөн хатгасан юм. Тогтоосон гэрээгээр /Петербургээс Хүрээ ба Бээжинтэй/ Хятад улс нь Гадаад Монголд эцэвэр нэрийн төдий эзэн эрх» олж авсан боловч хятадын засгийн газар өөрийн эрх ашиг ба сонирхлоо алдсан юм.

Цааш нь Орос дахь иргэний дайн ба эмх замбараагүй байдал нь Оросыг «гэрээг сахих боломжгүй» болгож байгааг тэмдэглэжээ. Түүнээс гадна буриадууд «орон нутгийн дээрэмчидтэй холбоо байгуулж» Гадаад Монголд хор хүргэхээс өөр ямар ч ашиг» авчрахгүй бүх монголчуудыг нэгтгэн тусгаар тогтносон нэгдмэл төр улс байгуулах төлөвлөгөө боловсруулсан. Боловсруулсан төлөвлөгөөг нь хүлээж авахгүй нь илэрхий болмогц Гадаад Монголыг бүх монголын улсад «айлган сүрдүүлж албадан зөвшөөрүүлэх замаар» оруулахын тул монголын эсрэг цэрэг илгээхээр санаархсан гэжээ.

Мөн өргөх бичигт Оросын цагаантны цэрэг эртнээс нааш Гадаад Монголын бүрэлдэхүүнд орж ирсэн Урианхайн хязгаарыг «хүчээр эзлэн авсан» тухай өгүүлжээ.

Өргөх бичиг зохиогчид Гадаад Монголд гаднаас заналхийлж байсан аюулаас уламжлаад Хүрээний засгийн газар «нэг бус удаа» ноёд лам нарын зөвлөлгөөнийг зарлан хуралдуулж Төв Засгийн /Бээжингийн газар нь дотоодын удирдлагыг эмх журамтай болгож гадаад нарийн төвөгтэй байдлаас хамгаалахын тулд бүх хүч чармайлтаа дайчлах зорилгоор урьдын засгийг хуучин хэвээр нь шууд хэрэгжүүлж төв засаг нь нэгтгэн нягтруулах байгууллага байхын тулд Манжийн төрийн хууль дүрмийг сэргээн тогтоохын учир автономийг халах саналаа бүгд илэрхийлсэн мэтээр баталцаажээ.

Орос монголын 1912 оны гэрээ Орос Хятадын 1913 оны монголын тухай тунхаглал, Хиагтын 1915 оны гурван этгээдийн гэрээний тухай айлтгал бичигт... эдгээр хууль эрхийн баримтууд нь тухайн үедээ автономит Монголд зориулагдаж байгуулагдсан бол эдүгээ Гадаад Монгол нь өөрөө автономиос татагалзахаа илэрхийлсэн учир эдгээр гэрээнүүд мэдээжийн хэрэг аяндаа хүчин төгөлдөр бус болж байгаа юм» хэмээж өгүүлсэн байна.»²⁵

БНХУ-ын ерөнхийлөгч 11 сарын 22-нд дээр өгүүлсэн айлтгал бичгийн агуулгыг хадгалсан зарлиг гаргав. Сюй Шижан зарлигтаа монголын сайд, ноёд, лам нар автономосоо татгалзаж иргэний засгийн дээд эрхийг Бээжингийн засгийн газарт шилжүүлсэн тухай хийгээд Гадаад Монголыг Хятадын автономит нэгэн хэсэг хэмээн тодорхойлсон олон улсын бүх хэлэлцээрүүдийг цуцалсныг мэдэгдсэн тухай зэрэг чухал баримт бичгийн зүйлүүдийг баталсан байна. Үүнээс гадна Хүрээний хутагт болон Халх дөрвөн аймаг, Шавийн захиргааны эрхийг хүндэтгэн үзэж хуучины Чин гүрний үеийн бүх хууль дүрмийг хэвээр мөрдүүлэх ёстой хэмээн зарлигт өгүүлжээ.²⁶

Мөн энэ өдөр Хятадын ерөнхийлөгч тусгай зарлиг гаргаж хүрээний хутагтын цолыг: Гадаад монголын Богд Жавзанданба хутагт Хан хэмээн өргөмжлөн баталж энэхүү цолонд «Ишан фухуа» /«Сайн үйлсэд туслагч ба гэгээрлийг даган баясагч» гэсэн чимэг нэмжээ.

11 сарын 24-нд Кудашёваас Хятадын ерөнхийлөгчийн тунхагаар Гадаад Монголын талаар Оростой байгуулсан бүх гэрээ хэлэлцээрүүд цуцлагдлаа гэсэн цахилгааныг Сукинд явуулжээ. Элчин төлөөлөгч Бээжин ба Хүрээнийхний эл ажиллагаа монголчуудын айлтгал бичгийн шалтгааныг нармай монголын хөдөлгөөн ба Омскийн засгийн газраас Урианхайн хязгаарт явуулсан цэргийн ажиллагаанаас үүдлээ хэмээн заасан» байна.²⁷ Мөн энэ өдөр Кудашёв Вайцзяобуд эсэргүүцлийн нот бичиг явуулав. Нот бичигт

улсуудын хоорондын гэрээг нэг тал нь дан ганцаар мэдэж цуцалж болохгүй», 1912-1915 оны гэрээнүүдийг үндэслэсэн Гадаад монгол дахь Орос улс, оросын харъяатууд ба оросын худалдааны хөдөлбөргүй оршин байгаа хэн ч халдаж болох эрхийг харгалзан үзэхгүйгээр бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Оросын засгийн газрын зөвшөөрөлгүй халах ёсгүй гэж өгүүлсэн байна²⁸. Хятадын ГЯЯ Кудашёвын эсэргүүцлийг няцаан автономийг халах явдал «монголчуудын өөрсдийнх нь хүслээр» болж өнгөрсөн хэмээжээ. А.Орлов Цэрэндоржид эсэргүүцэл гардуулах гэсэн боловч тэрбээр эсэргүүцлийг хүлээн авсангүй ажээ. Кудашёв 11 сарын 28-ны өдөр Бээжин дэх Англи Францын элчингүүдтэй ярилцав. Тэдгээр ярианаас Кудашёв антантын орнууд монголын асуудал дээр биднийг дэмжихэд дуртай байгаа биш төдийгүй тэдний зүгээс 7 Хятадын ерөнхийлөгчийн тунхагийг хүчингүй болгоход тус болохыг хүлээгээд ч хэцүү юм байна гэсэн сэтгэгдэл төржээ. Элчин төлөөлөгчөөс монголын тухай хэлэлцээний араас Оростой байгуулсан ДХТЗ ба Баргын тухай байгуулсан гэрээг хүчингүй болгох явдал дагалдаж болзошгүйг Сукинд анхааруулжээ.²⁹ С.Д.Сазанов Парист АНУ, Англи, Францын засгийн газарт хандан «монгол дахь Хятадын дур зоргын үйл ажиллагаа»³⁰-г эсэргүүцэхийг хүсэв. Гэвч эдгээр эсэргүүцлүүд Бээжингийн хувьд аль хэдийн ач холбогдлоо алдсан байлаа. Учир нь гэвэл тухайн үед Гадаад Монгол дахь Хятадын үйл ажиллагааг хэн ч зогсоох боломжгүй болсон байлаа.

1919 оны 12 сард монголын засгийн газар ба монголын цэргийг татан буулгаж Богд хаан ба Оросын консулын газрыг хамгаалж байсан цөөхөн тооны цэргийг үлдээжээ. Хятадын эрх баригчдад монголчууд 5776 винтов ба винтовын 874362 сум, 2456 берданк ба берданкны 714779 сум, 7 их буу 5410 сум, 10 пулемёт, 12 гар буу, 2608 орос сэлэм шилжүүлж өгөв. Хүрээ ба Маймаагингийн цахилгаан утас ба телефон Хятадуудын гарт шилжив. Оросын цэргийнхэн ба дипломатууд монголын засгийн газарт ажиллаж байсан зөвлөхүүд ажил хэргийн гадна үлдэж тэдэнд яамдын байр ба хотын төвд амьдарч байсан байр оронгоо орхихыг тушаав. А.Орлов түүний консулын газрыг хятадууд хаахаас айж эсрэгүүцэхээ хэдийн больсон байв. Тэрбээр Гадаад Монгол дахь Хятадын захиргааг чухам байгаагийг нь хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болжээ. 1920 онд Хятад ба ЗСБНХУ-ын хооронд хэлэлцэж эхлэв. Хэлэлцээр мөн оны 9-р сард Бээжин дэх Оросын төлөөлөгчийн газар ба Хятад дахь оросын бүх консулын газрыг Бээжингийн засгийн газар хаахад хүргэлээ. Орос Хятадын харилцаанд шинэ үе эхлэв.

Бадамдоржоос 1920 оны 1 сард хошуудад тараасан захирамж бичигт Гадаад Монголын автономийг халах олон үндсэн шалтгааныг нармай монголын хөдөлгөөний зүгээс учруулсан аюул ба Хүрээний

засгийн газарт хангалттай цэргийн хүч байгаагүйтэй холбон тайлбарлажээ.³¹ Миний үзэхэд үндсэн шалтгаан нь өөр зүйлд байв.

Гадаад монголын автономии 1912-1915 оны /Петербург, Хүрээ, Бээжингийн гэрээнүүдээр тодорхой хэмжээний дарамт шахалтын дор байгуулагдаж байжээ. Орос орон хүчирхэг төртэй улс байх үед Гадаад Монголын тухай гэрээнүүд хэлбэрэлтгүй мөрдөгдөж байв.

1918 онд Орост иргэний дайн эхэлснээр Хятад болон Монголд Хойд хөршийн нөлөө үлэмж суларчээ. Энэ нөхцөл байдлыг Хятад ашиглан 1918 оны зун Хиагтын гурван этгээдийн гэрээ, тухайлбал, энэ гэрээнд заасан Оросын эрхийг эвдэн цэргийн анги /хүч нэмэгдүүлсэн батальон/-г оруулан зөрчсөн юм.

А.В. Колчакийн засгийн газар Монголын тухайд хаант засгийн газар ба Түр Засгийн Газрын бодлогыг хэвээр үргэлжлүүлж ирсэн бөгөөд: Гадаад Монгол нь Хятадын автономит хэсэг байх ёстой ба Орос нь монголд эдийн засгийн болон улс төрийн хүчтэй байр суурьтай байх ёстой гэж үзэж байсан авч Колчакийн засгийн газар нь Хаант ба Түр Засгийн Газартай харьцуулшгүй сул дорой байв. 1919 оны намар гэхэд Омскийн засгийн газарт илт болж Улаан армийн цохилтод нурж эхлэх нь Бээжингийн засгийн газар нь байж үүнийг гадаад монголын автономийг халахад тохиромжтой цаг боллоо гэж Бээжингийн засгийн газар үзсэн юм. Бээжин монголд цэрэг оруулж монголчуудын автономисоо татгалзахыг албаджээ.

Монголын феодал дээдэс энэ үед дотроо хагаралдаж ноёд ба лам нарын «нам»-уудын хоорондын зөрчил ихээхэн хурцадсан байв. Үүнийг тухайлбал хааны ордны хавийн лам нарын бүлэглэл засгийн газрын тэргүүн, ноёдын намын удирдагч Сайн ноён хан Намнансүрэнг хорлосон хэрэг явдал гэрчилнэ. Ноёдын үлэмж хэсэг нь Хятадын удирдлагад орвол илүү аюулгүй илүү баян амьдарна хэмээн найдаж автономийг устгах байр суурийг баримтлах болсон байна. Монголын эрх баригч дээдэсийн хагарал гадаад монголын автономийг устгах хятадын санааг хэрэгжүүлэх явдлыг мэдэгдэхүйц хөнгөвчилж өгчээ.

Хүрээний засгийн газар 1918-1919 онд Урианхайн хязгаарт монгол Хятадын захиргаа тогтоох гэж хятадуудтай хамтын ажиллагаанд орсноороо стратегийн алдаа гаргажээ. Миний үзэж байгаагаар эдгээр жилүүдэд монголчууд өөрийн автономийг хамгаалахад цэргийн болоод дипломатын хүчээ төвлөрүүлэх гол зорилт нь байх ёстой байжээ. Урианхайн хязгаарын асуудалтай зууралдсанаараа монголын засгийн газар өөрийгөө сулруулж Гадаад Монголын автономийг устгах хэрэгт хятадуудад илүү шургуу хатуу ажиллах бололцоо олгожээ.

Хятад болоод Монголын эрх баригчдын хувьд Октябрийн хувьсгал зөвлөлт засгийн нөлөөг өөрсдийн оронд тусахаас айсан тухайд бол энэ хүчин зүйл ямар нэг хэмжээгээр байсан хэдий ч Гадаад Монголын автономийг халахад хүргэсэн үйл явдлуудад шийдвэрлэх үүрэг гүйцэтгээгүй юм. Гадаад Монголын хувь заяаг тодорхойлсон шийдвэрлэгч хүчин зүйл бол Орос орон урт хугацааны иргэний дайны уршгаар ер бус их сулран доройтсон явдал болсон юм.

Оросоос орчуулсан Д.Тод

Зүүлт

1. 1919 оны хавар зун Нэйс гэгээн атаман Семеновын заавраар нэгдсэн монгол улс гэгчийн цэргийг Гадаад Монголд илгээж нармай монголын хөдөлгөөнд хүчээр нэгтгэнэ хэмээн мэдэгджээ.
2. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д.335, 72-73
3. А.Орловоос И.И.Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 7 сарын 8. 200. Оп 1.д.479.л.45
4. Кудашёваас Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 7 . сарын 17. мөн тэнд д.478 л.235
5. Кудашеваас Сукинд илгээсэн нууц захидал. 1919 оны 7 сарын 24. АВРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324 л. 56-62.
6. Мөн тэнд л. 57.
7. А.Орловоос И.И.Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 10 сарын 1. ГАРФ. ф.200.0п 1.д.479 .л. 14
8. 1912 оны 3 сард Нанкины үндэсний хурлаас Сунь-Янь- Сений санаачлагаар батлагдсан БНХУ-ын түр үндсэн хуулиар хань, манж, монгол, төвд, мусульман эрх тэгш таван үндэстнээс бүрдсэн Хятадын бүгд найрамдах улс байгуулагдсаныг тунхаглажээ.
9. Б.Ширэндэв. Зарлиг, гэрээнүүд. х 176-177
10. А.Орловоос И.И.Сукинд илгээсэн нууц захидлын хуулбар. 1919 оны 12 сарын 24. ГАРФ. Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар д. 324.л.174.
11. А.Орловоос И.И.Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 10 сарын 29. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324. л. 73. Бригад явган цэргийн хоёр хороо, морьт цэргийн хороо, уулын их бууны батерей ба пулемётын командаас бүрдэж байв.
12. А.Орловоос И.И.Сукинд илгээсэн нууц захидлын хуулбар. 1919 оны 12 сарын 24. ГАРФ. ф.200.0п 1.д 324. 176.
13. ГАРФ. ф.200.0п 1.д 945.л. 86.
14. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324.л.75.

15. Чэнь и тухайбал Цэрэндоржоос тавьсан Богд хааны хэргэм зэрэг шагнах эрх ба барга өвөр монголчуудын Халхад чөлөөтэй нэвтэрч байх эрхийг хэвээр хадгалах саналыг хүлээж аваагүй.
16. Мөн тэнд. л. 178.
17. 1919 оны 4 сарын 13-нд Хүрээний засгийн газар нармай монголын хөдөлгөөний тэргүүлэгчдээс 1919 оны 3 срад Читад тунхагласан тусгаар тогтносон нэгдмэл монгол улсад Гадаад монголыг нэгдэхийг хүссэн хүсэлтийг няцааж 1915 оны Хиагтын гэрээнд үнэнч гэдгээ мэдэгдсэн.
18. Мөн тэнд.л. 179.
19. Мөн тэнд.л. 179-180.
20. Мөн тэнд.л. 180.
21. Мөн тэнд.л.181-182.
22. Мөн тэнд.л. 182.
23. Миний бичсэн «Урианхай хязгаарын төлөө тэмцэл. 1915 1919 он» гэсэн өгүүлэл «эх орны түүх» сэтгүүлд 1996 онд нийтлэгдэнэ.
24. Мөн тэнд.л. 182-183.
25. Мөн тэнд.л. 97-100.
26. «Чжэнфу гунбао» 1919 оны 11 сарын 23. Мөн тэнд.л.101.
27. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324.л. 112.
28. Мөн тэнд. л. 113.
29. Кудашёваас Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 11 сарын 28.
30. С.Д. Сарзановоос Сукинд илгээсэн нууц цахилгаан. 1919 оны 12 сарын 16, мөн тэнд. д. 445, л. 130. С.Д. Сазанов 1910-1915 онд Оросын гадаад явдлын яамны сайд, 1918-1920 онд Парисын энх тайвны бага хуралд А.В.Колчак ба А.И. Деникиний засгийн газрыг төлөөлж байсан
31. АВПРИ, Ф. Бээжин дэх төлөөлөгчийн газар. д 324.л. 197.
32. Мөн тэнд. л.193.

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ,
ЦААШДЫН ХЭРЭГЦЭЭ

О.Батсайхан.*

Дэлхий дахинд өрнөсөн их өөрчлөлт шинэчлэлийн урсгалд Монгол улс 1990 оноос алхаа нэгдэн орсон билээ. Энэ үе нь социалист систем задарч, ЗХУ бутарсан үетэй давхацсан нь ЗХУ-ын болон ЭЗХТЗ-ийн тусламж дэмжлэгт түшиглэн оршиж байсан

* Гадаад харилцааны Яамны ажилтан